



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2025/32/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дундговь аймаг 2025 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Oyunerdenet@audit.gov.mn">Oyunerdenet@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:Batsaikhant@audit.gov.mn">Batsaikhant@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:Doljinsurend@audit.gov.mn">Doljinsurend@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

0

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	11
3.1 Төлбөрийн акт.....	11
3.2 Албан шаардлага.....	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

#### Товчилсон үгийн жагсаалт

ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ЭЭС	Эм эргэлтийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.02.17 № 04

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвөөс гаргах баяр наадмын зардлыг санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс 40.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 2 дахин их байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/"-ийн 1-д заасан заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалин нэмсэн, бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож эхэлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 291.6 сая төгрөгөөр өссөн байна. Мөн орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг төрийн захиргааны албан хаагчдад олгож эхэлснээр 2024 онд 4 албан хаагч 28.8 сая төгрөгийн дэмжлэг авсан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

0025000018

Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 16 дугаар тогтоолын дагуу сумдын Эмийн эргэлтийн санг татан буулгах шийдвэр гарч, тус сумын Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 42.7 сая төгрөгийн хөрөнгө, 32.2 сая төгрөгийн өр төлбөрийг ЗДТГ-ын санхүүгийн тайланд нэгтгэн бүртгэсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд Азийн хөгжлийн банкны урт хугацаат зээлээр хэрэгжиж байгаа “Усан хангамж, ариутгах татуурга” байгууламжийн үндсэн хөрөнгийг 1,939,828.2 мянган төгрөгөөр нэмж, урт хугацаат өглөгөөр тайлагнасан нь хэрхэн төлөх нь тодорхойгүй тайлант үеийн өндөр үнэлэгдсэн эрсдэлтэй асуудал байлаа.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 39 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 91.7 хувьтай үнэлэгдсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	362,012,005.73	354,596,347.97
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,488.00	4,057,272.24
312	Банканд байгаа бэлэн мөнгө	11,488.00	4,057,272.24
3121	Төгрөг	11,488.00	4,057,272.24
31213	Арилжааны банк дахь харилцах		4,045,784.24
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	11,488.00	11,488.00
33	АВЛАГА	13,256,000.00	3,311,060.00
335	Бусад авлага	13,256,000.00	3,311,060.00
3351	Байгууллагаас авах авлага	13,256,000.00	3,311,060.00
35	БАРАА МАТЕРИАЛ	188,544,517.73	187,028,015.73
351	Түүхий эд материал	59,218,500.00	49,789,036.00
3511	Тусгай зориулалттай материал	59,218,500.00	41,946,900.00
3513	Эм боох материал		7,842,136.00
354	Хангамжийн материал	128,063,017.73	128,988,979.73
3541	Бичиг хэргийн материал	3,893,950.00	2,947,190.00
3542	Аж ахуйн материал	117,448,067.73	118,379,789.73
3543	Сэлбэг хэрэгсэл	21,000.00	4,942,000.00
3545	Барилгын засварын материал	6,700,000.00	1,500,000.00
3546	Хүнсний материал		1,220,000.00
356	Мал амьтад	1,263,000.00	8,250,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	160,200,000.00	160,200,000.00
368	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	160,200,000.00	160,200,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,536,575,684.37	4,984,409,147.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,536,575,684.37	4,984,409,147.15
392	Биет хөрөнгө	3,477,100,871.95	4,924,346,459.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,033,926,827.67	4,756,224,846.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-810,752,257.41	-891,565,402.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	449,540,278.00	433,305,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-164,613,861.43	-151,307,156.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	896,089,409.02	721,924,051.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-146,482,192.66	-143,030,255.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	244,295,235.98	244,079,733.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,508,900.64	-49,407,355.63
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,250,000.00	4,905,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,991,666.58	-981,999.91
39217	Ном	348,000.00	200,000.00
393	Биет бус хөрөнгө	59,474,812.42	60,062,687.34
39301	Програм хангамж	5,966,625.00	6,036,625.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,669,812.58	-1,751,937.66
39303	Бусад биет бус хөрөнгө	55,178,000.00	55,778,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,898,587,690.10	5,339,005,495.12
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,266,927.00	1,972,039,355.12
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,266,927.00	32,211,111.81

413	Өглөг	2,266,927.00	32,211,111.81
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	2,266,927.00	
4136	Бусад өглөг		32,211,111.81
41361	Байгууллагад төлөх өглөг		29,538,739.81
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		2,672,372.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,939,828,243.31
422	Урт хугацаат зээл		1,939,828,243.31
4221	Төгрөг		1,939,828,243.31
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв		1,939,828,243.31
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,896,320,763.10	3,366,966,140.00
51	Засгийн газрын хувь оролцоо	3,896,320,763.10	3,366,966,140.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	834,989,767.22	834,989,767.22
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	834,989,767.22	834,989,767.22
512	Хуримтлагдсан үр дүн	2,396,592,638.35	1,867,238,015.25
5121	Өмнөх үеийн үр дүн	2,396,592,638.35	2,396,592,638.35
5122	Тайлант үеийн үр дүн		-529,354,623.10
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	664,738,357.53	664,738,357.53
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,898,587,690.10	5,339,005,495.12

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,326,232,449.30	2,052,935,200.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,435,089,884.30	399,665,746.37
120	Нийтлэг татварын бус орлого	1,435,089,884.30	399,665,746.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,398,988.00	18,579,949.95
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,287,500.00	1,348,105.71
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		13,186,060.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	111,488.00	4,045,784.24
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,243,934,421.30	311,453,660.42
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	181,756,475.00	69,632,136.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	891,142,565.00	1,653,269,454.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,251,665.00	208,911,554.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,917,151.00	161,447,851.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,334,514.00	43,463,703.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	847,890,900.00	1,444,357,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	847,890,900.00	1,444,357,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,266,760,668.88	2,068,139,545.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,266,760,668.88	2,068,139,545.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,248,865,230.25	1,994,732,095.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	473,910,547.51	757,673,909.98
210101	Үндсэн цалин	305,944,975.64	479,374,561.33
210102	Нэмэгдэл	134,339,283.77	200,543,773.66
210104	Урамшуулал	33,626,288.10	23,407,950.00
210105	Гэрээт ажлын хөлс		54,347,624.99

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,893,836.96	94,076,543.00
210201	Тэтгэврийн даатгал	41,160,403.07	64,526,082.95
210202	Тэтгэмжийн даатгал	4,842,470.24	7,593,275.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,612,845.70	3,791,986.46
210204	Ажилгүйдлийн даатгал	925,831.73	3,631,044.20
210205	Эрүүл мэндийн даатгал	9,352,286.22	14,534,153.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,764,869.91	104,668,285.20
210301	Гэрэл, цахилгаан	26,669,417.91	40,173,044.20
210302	Түлш, халаалт	57,095,452.00	63,495,241.00
210303	Цэвэр, бохир ус		1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,670,013.19	102,731,473.00
210401	Бичиг хэрэг	8,510,250.00	8,460,150.00
210402	Тээвэр, шатахуун	46,510,477.00	47,367,445.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,417,286.19	4,362,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,000.00	17,900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,182,000.00	24,641,878.00
2105	Нормативт зардал		4,050,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		4,050,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,512,020.00	18,127,100.00
210604	Урсгал засвар	46,512,020.00	18,127,100.00
2107	Томилолт, зочны зардал	18,324,400.00	20,106,000.00
210702	Дотоод албан томилолт	18,324,400.00	20,106,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,941,064.00	210,044,824.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,900,664.00	208,502,304.72
210804	Тээврийн хэрэгслийн татвар	372,420.00	534,120.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	274,980.00	524,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	474,848,478.68	683,253,959.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	142,553,824.80	251,654,684.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		3,130,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	332,294,653.88	428,469,275.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,895,438.63	73,407,450.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,842,200.00	43,491,857.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,241,200.00	11,233,875.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		28,757,982.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,601,000.00	3,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,053,238.63	29,915,593.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,053,238.63	29,915,593.81
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,059,471,780.42	-15,204,345.53
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	75,606,482.82	514,150,277.57
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	75,606,482.82	410,622,165.76
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		46,460,111.81
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал		57,068,000.00

IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-75,606,482.82	-514,150,277.57
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	983,865,297.60	-529,354,623.10

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	900,541,553.00	1,658,663,343.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,398,988.00	5,393,889.95
120	Нийтлэг татварын бус орлого	9,398,988.00	5,393,889.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,398,988.00	5,393,889.95
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,287,500.00	1,348,105.71
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	111,488.00	4,045,784.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	891,142,565.00	1,653,269,454.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,251,665.00	208,911,554.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,917,151.00	161,447,851.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,334,514.00	43,463,703.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	847,890,900.00	1,444,357,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	847,890,900.00	1,444,357,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	900,402,083.00	1,620,899,559.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	900,402,083.00	1,620,899,559.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	882,506,644.37	1,547,492,108.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	468,250,553.51	759,940,836.98
210101	Үндсэн цалин	300,284,981.64	480,899,463.43
210102	Нэмэгдэл	134,339,283.77	201,285,798.56
210104	Урамшуулал	33,626,288.10	23,407,950.00
210105	Гэрээт ажлын хөлс		54,347,624.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,893,818.96	94,076,543.00
210201	Тэтгэврийн даатгал	41,160,403.07	64,526,082.95
210202	Тэтгэмжийн даатгал	4,842,470.24	7,593,275.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,612,845.70	3,791,986.46
210204	Ажилгүйдлийн даатгал	925,831.73	3,631,044.20
210205	Эрүүл мэндийн даатгал	9,352,268.22	14,534,153.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,764,869.91	104,668,285.20
210301	Гэрэл, цахилгаан	26,669,417.91	40,173,044.20
210302	Түлш, халаалт	57,095,452.00	63,495,241.00
210303	Цэвэр, бохир ус		1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,367,263.19	88,021,435.00
210401	Бичиг хэрэг	8,152,500.00	6,430,800.00
210402	Тээвэр, шатахуун	46,510,477.00	47,367,445.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,417,286.19	4,362,000.00
210404	Ном, хэвлэл	55,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,000.00	17,900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,182,000.00	11,961,190.00
2105	Нормативт зардал	2,650,000.00	5,070,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,650,000.00	5,070,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,512,020.00	20,246,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		282,000.00
210604	Урсгал засвар	46,512,020.00	19,964,000.00
2107	Томилолт, зочны зардал	18,324,400.00	20,106,000.00
210702	Дотоод албан томилолт	18,324,400.00	20,106,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,941,064.00	210,044,824.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,900,664.00	208,502,304.72
210804	Тээврийн хэрэгслийн татвар	372,420.00	534,120.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	274,980.00	524,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,802,654.80	245,318,184.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,802,654.80	242,008,184.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		3,310,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,895,438.63	73,407,450.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,842,200.00	43,491,857.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,241,200.00	11,233,875.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		28,757,982.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,601,000.00	3,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,053,238.63	29,915,593.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,053,238.63	29,915,593.81
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	139,470.00	37,763,784.24
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	128,000.00	33,718,000.00
	Дотоод эх үүсвэрээр	128,000.00	33,718,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	128,000.00	33,718,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-128,000.00	-33,718,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	11,470.00	4,045,784.24
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		11,488.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,057,272.24

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	834,989,767.22	664,738,357.53	1,411,772,775.07	2,911,500,899.82
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			954,529.68	954,529.68
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	834,989,767.22	664,738,357.53	1,412,727,304.75	2,912,455,429.50
7	Тайлант үеийн үр дүн			983,865,333.60	983,865,333.60
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	834,989,767.22	664,738,357.53	2,396,592,638.35	3,896,320,763.10
17	Тайлант үеийн үр дүн			-529,354,623.10	-529,354,623.10
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	834,989,767.22	664,738,357.53	1,867,238,015.25	3,366,966,140.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,454,357,900.00	1,420,623,488.05	33,734,411.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,454,357,900.00	1,420,623,488.05	33,734,411.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,410,819,900.00	1,377,131,631.05	33,688,268.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	704,888,000.00	674,974,461.74	29,913,538.26
210101	Үндсэн цалин	414,526,000.00	395,933,088.19	18,592,911.81
210102	Нэмэгдэл	211,268,000.00	201,285,798.56	9,982,201.44
210104	Урамшуулал	23,410,000.00	23,407,950.00	2,050.00
210105	Гэрээт ажлын хөлс	55,684,000.00	54,347,624.99	1,336,375.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,702,500.00	83,787,279.39	1,915,220.61
210201	Тэтгэврийн даатгал	58,272,800.00	57,529,383.47	743,416.53
210202	Тэтгэмжийн даатгал	6,849,400.00	6,775,498.04	73,901.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,446,200.00	3,381,199.02	65,000.98
210204	Ажилгүйдлийн даатгал	3,446,200.00	3,220,256.76	225,943.24
210205	Эрүүл мэндийн даатгал	13,687,900.00	12,880,942.10	806,957.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,343,300.00	98,279,235.20	64,064.80
210301	Гэрэл, цахилгаан	33,847,300.00	33,783,994.20	63,305.80
210302	Түлш, халаалт	63,496,000.00	63,495,241.00	759.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	75,621,500.00	78,323,245.00	-2,701,745.00
210401	Бичиг хэрэг	5,926,000.00	5,926,000.00	
210402	Тээвэр, шатахуун	35,471,500.00	38,174,055.00	-2,702,555.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,362,000.00	4,362,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,900,000.00	17,900,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,962,000.00	11,961,190.00	810.00
2105	Нормативт зардал	3,000,000.00	3,000,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	3,000,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,964,000.00	53,964,000.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00	
210602	Тавилга	19,000,000.00	19,000,000.00	
210604	Урсгал засвар	19,964,000.00	19,964,000.00	
2107	Томилолт, зочны зардал	18,596,000.00	18,596,000.00	
210702	Дотоод албан томилолт	18,596,000.00	18,596,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	210,561,600.00	208,769,074.72	1,792,525.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	207,229,200.00	207,226,554.72	2,645.28
210803	Даатгалын үйлчилгээ	922,400.00		922,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	542,000.00	534,120.00	7,880.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	283,000.00	44,000.00	239,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	684,000.00	440,000.00	244,000.00
210807	Газрын төлбөр	901,000.00	524,400.00	376,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,143,000.00	157,438,335.00	2,704,665.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	156,833,000.00	154,128,335.00	2,704,665.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,310,000.00	3,310,000.00	

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,538,000.00	43,491,857.00	46,143.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,538,000.00	43,491,857.00	46,143.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,280,000.00	11,233,875.00	46,125.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,758,000.00	28,757,982.00	18.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	3,500,000.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,454,357,900.00	1,420,612,000.05	33,745,899.95
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,454,357,900.00	1,420,623,488.05	33,734,411.95
132001	Орон нутгийн төсвөөс	1,454,357,900.00	1,420,623,488.05	33,734,411.95
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		-11,488.00	11,488.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		-11,488.00	11,488.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	208,911,554.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	208,911,554.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	204,078,477.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	84,966,375.24
210101	Үндсэн цалин	84,966,375.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,289,263.61
210201	Тэтгэврийн даатгал	6,996,699.48
210202	Тэтгэмжийн даатгал	817,777.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	410,787.44
210204	Ажилгүйдлийн даатгал	410,787.44
210205	Эрүүл мэндийн даатгал	1,653,211.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,389,050.00
210301	Гэрэл, цахилгаан	6,389,050.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,698,190.00
210401	Бичиг хэрэг	504,800.00
210402	Тээвэр, шатахуун	9,193,390.00
2105	Нормативт зардал	2,070,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,070,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,510,000.00
210702	Дотоод албан томилолт	1,510,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,275,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,275,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,879,849.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,879,849.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,833,076.15
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,833,076.15
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	208,911,554.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	208,911,554.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,000,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	161,447,851.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,463,703.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 105,485.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 40,300.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 1,953.2 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 63,232.0 мянган төгрөгийн 5 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг тус тус хүргүүлээ.

#### Залруулсан алдаа:

Аудитаар нийт 40,300.0 мянган төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Түрээсийн 300.0 мянган төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан;
- Аймгийн ОНХС-аар хийгдсэн 40,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй.

#### Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 65,185.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч, нөхөн төлүүлэх төлбөрийн акт, зөрчил арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

#### 3.1 Төлбөрийн акт

- Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ажил үүрэг, үр дүнг тооцон нэмэгдэл, урамшуулалд 1,141.8 мянган төгрөг олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т */Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/*, Төрийн албаны тухай хуулийн 48.7-д */Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно./*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.7-д */Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй/* заасныг;
- Ажил тасалсан албан хаагчид сарын цалинг бүтэн бодож 133.3 мянган төгрөгийг илүү олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т */Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т */Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан маягт, заавар батлах тухай НХМаягт ЦХ-4 */Цалингийн тооцооны картыг ажлын цагийн тооцоо, ажлын даалгаврыг үндэслэн, цалин хөлс хариуцсан нягтлан бодогч сард нэг удаа нөхөн бичиж дарга, ерөнхий нягтлан бодогчоор батлуулж тамга тэмдэг дарсан байна/* заасныг;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 678.1 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т */Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3.-т */ хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/*, Засгийн газрын 2019 оны 5 тогтоолын Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-т */Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна./* заасныг тус тус зөрчсөн.

*Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар илүү болон давхардуулан олгосон 1,953.2 мянган төгрөгийг орон нутгийн орлогот төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 2024 оны жилийн эцсээр бүрэн барагдуулсан байна.*

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.2 Албан шаардлага

- Аудитаар олон жилийн өмнө үрэгдсэн 2,800.0 мянган төгрөгийн 2 мотоциклийг актлаагүй, хөрөнгийн бүртгэлээс хасаагүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т /байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн.
- Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй худгийг гэрээ, хэлэлцээргүй бусдад ашиглуулсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т /Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно/, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т /Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх/ заасныг тус тус зөрчсөн.

*Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар зөрчлийг таслан зогсоож, арилгах 2 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.*

- Баяр наадмын зардлыг жишиг дээд хэмжээнээс 40,000.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн төсвөөс зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/", Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь 1-д /Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай/ заасныг;
- Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй этгээдээс 14,718.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 38 дүгээр зүйлийн 38.1-т /Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна/, 38.5-д /Цахим дэлгүүрт нэг гүйцэтгэгч байгаа, эсхүл үнийн санал дуудахад үнийн санал ирээгүй бол захиалагч цахим дэлгүүрт бүртгэгдсэн хамгийн бага үнийн санал бүхий бараа, үйлчилгээг худалдан авч болно/, Төрийн хэмнэлтийн хуулийн 14 дүгээр зүйл 14.4-т /Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно/ заасныг;
- Санхүүгийн албан хаагчдын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн 5,714.0 мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшууллыг давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т /улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т /Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно/ 15.1.3-т /Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т /Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна/ заасныг тус тус зөрчсөн.

*Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн аудитаар зөрчлийг таслан зогсоох 3 албан шаардлага хүргүүлээ.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Түрээсийн орлогыг дутуу тайлагнасан	1	300.0	1	300.0			1	300.0		
Аймгийн ОНХС-аар хийгдсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	1	40,000.0	1	40,000.0			1	40,000.0		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>40,300.0</b>	<b>2</b>	<b>40,300.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>40,300.0</b>	<b>0</b>	<b>0</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажил тасалсан албан хаагчид сарын цалинг бүтэн бодож, олгосон.	1	133.3	1	133.3						
Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ажил үүрэг, үр дүнг тооцон нэмэгдэл, урамшуулал олгосон.	1	1,141.8	1	1,141.8						
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин урамшууллыг давхардуулан олгосон.	1	678.1	1	678.1						
Аудитаар олон жилийн өмнө үрэгдсэн 2 мотоциклийг актлаагүй, хөрөнгийн бүртгэлээс хасаагүй	1	2,800.0			1	2,800.0				
Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй худгийг гэрээ, хэлэлцээргүй бусдад ашиглуулсан	1	0.0			1	0.0				
Санхүүгийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшууллыг давхардуулан олгосон.	1	5,714.0			1	5,714.0				
Баяр наадмын зардлыг төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс хэтрүүлэн зарцуулсан	1	40,000	1	3,560.0	1	40,000.0				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>50,467.2</b>	<b>4.00</b>	<b>5,513.2</b>	<b>4.00</b>	<b>48,514.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй этгээдээс тоног төхөөрөмж худалдан авсан.	1	14,718.0			1	14,718.0				
Дүн	1	14,718.0	-	-	1	14,718.0	-	-	-	-

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		